



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот


┌ Хөрөнгө гаргах тухай ┐

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамжийн хавсралтын 32, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оросын Холбооны Улсын зах зээлд Улаанбаатар хотыг сурталчлах сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх ажлыг бага үнийн санал ирүүлсэн "Ноа Ничи Мон" ХХК-иар гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Болортуяа/-д даалгасугай.

2. Сурталчилгааны материал хэвлүүлэх зардал 6,000,000 /зургаан сая/ төгрөгийг батлагдсан төсвөөс гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА